# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр Дугаар А/81 Номгон

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга
хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 102 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хангах 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал 3.0 сая /Гурван сая/ төгрөгийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Сарангарав/-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын
29-ний өдрийн А/81 дүгээр захирамжийн хавсралт

## “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилго | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд нутгийн өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн болон хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн системийн аюулгүй байдлыг цогцоор нь бүрдүүлэх замаар зам тээврийн ослын шалтгаан болж байгаа сөрөг үр дагаврыг бууруулахад оршино. | | | | |
| Үр нөлөө | | 1.Аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавх дээшилж, зам тээврийн ослын тоог багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч нэг баг болж ажиллана.<br>2.Иргэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөл бүрдэнэ.<br>3. Иргэд, олон нийт замын хөдөлгөөнд аюулгүй оролцох мэдлэг, дадалтай болно.<br>4.Зам тээврийн осолд өртсөн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ. | | | | |
| **д/д** | **Үйл ажиллагаа** | **Шалгуур үзүүлэлт** | **Хугацаа** | **Хэрэгжилтийг хариуцах байгууллага** | **Хамтран хэрэгжүүлэх байгууллага** | **Төсөв мян/төг** |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** |
| **Зорилт 1. “Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах” гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд** | | | | | | |
| 1 | Авто замтай ойр сургууль, цэцэрлэг, явган зорчигчийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй гудамж замын судалгааг гарган холбогдох байгууллагад аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр санал, танилцуулга хүргүүлж хамтран анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээ хийх. | Явган зорчигчийн аюулгүй байдал хангагдсан байна. | 1 дүгээр улиралд | Дэд зөвлөл, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Төрийн байгууллагууд | 1.0 сая/төг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Замын хөдөлгөөнийг өөрчлөн зохион байгуулахтай холбоотой санал, танилцуулгыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлэх | Замын хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотой санал танилцуулага хүргэгдсэн байна. | 3 сард | Дэд зөвлөл, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | - | - |
| **Зорилт 2. “Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах”** | | | | | | |
| 1 | Суурин газрын авто замын дагуу явган зорчигч, унадаг дугуйн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнөөс тусгаарласан зохион байгуулалтын шийдлийг бий болгох шаардлагатай судалгааг гаргах | Суурийн газарт зорчих хэсгийн дагуу явган хүний хөдөлгөөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрэн тусгаарласан байна | Хагас жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглох зам, явган хүний гарцын судалгаа холбогдох байгууллагад гарган өгч, хамтран ажиллаж аюулгүй байдлыг хангах. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэг, иргэдийн амьдардаг байрны ойролцоо замын явган хүний гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглох талаар судалгаа хийж, холбогдох байгуулллагад хүргүүлсэн байна. | 6 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| | Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох, харанхуй үед замын бусад байгууламжаас илт ялгарах техникийн шийдлийг бий болгох ажилд дэмжлэг үзүүлэн оролцож, холбогдох стандарыг шинэчлэхэд санал өгөх. | Явган хүний гарцын техникийн шаардлага, стандартын өөрчлөлтөд санал боловсруулж хүргүүлсэн байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Жолооч нь хөдөлмөр амралтын горим зөрчсөн эсвэл холбогдох хуульд нийцүүлээгүй, мөн жолоочийн ажил үүргийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг шаардлагад нийцүүлэн зохион байгуулаагүйгээс гарсан зам тээврийн ослын судалгааг гаргах. | Жолоочийн хөдөлмөр, амралтын горим зөрчсөнөөс үүдэлтэй зам тээврийн ослын шалтгаан нөхцлийн талаарх судалгааг гаргасан байна. | 3 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 3 | Урьд онд гарсан зам тээврийн осол, хэрэг, зөрчилд судалгаа хийж, судалгаанд үндэслэн зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн аян, арга хэмжээ зохион байгуулах. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан компанит ажлын үр дүнд зам тээврийн осол буурсан байна. | 3 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | 500.0 мян/төг |
| 4 | Жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагааны чиглэлээр замын хөдөлгөөний дүрмийн шалгалт авах өрөөг тохижуулах. | Эрэлт хэрэгцээнд нйицсэн жишиг төв байгуулагдсан байна. | 6 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | 500.0 Мян/төг |
| 5 | Жолооч бэлтгэх арга, хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгох, мэргэшүүлэх, шалгах үйл ажиллагаанд хүнээс хамаарсан хамаарлыг багасгах чиглэлээр судалгааг хийж, холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлэх. | Жолоочийн шалгалт авдаг, дүгнэх үйл ажиллагааг хүнээс хамаарсан байдлыг өөрчлөх санал, танилцуулга хүргэгдсэн байна. | 3 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах уралдаан тэмцээн, арга хэмжээнд идэвхтэй оролцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах | Хүүхдийн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх тэмцээн уралдааныг зохион байгуулснаар бага насны хүүхдүүдийн замын хөдөлгөөнд оролцох мэдлэг дээшилнэ. | 5, 10 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | 500.0 мян/төг |
| 7 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан сургалтуудад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. | Жилийн турш | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл “Майхан цахир” ХХК | - |
| 8 | Сургуулийн бүс Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагуудад санал танилцуулга хүргүүлэх. | Холбогдох байгууллагад судалгаа, санал хүргүүлсэн байна. | 4 сард | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |
| 9 | Цагдаагийн байгууллагаас зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг цаг алдалгүй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллах. | Зохион байгуулж байгаа үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Жилийн турш | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 10 | Зам тээврийн гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх ажилд даатгалын байгууллагууд, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж, хамтран ажиллах. | Даатгалын байгууллагууд, иргэн, хуулийн этгээдийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж тодорхой үр дүнд хүрсэн байна. | Жилийн турш | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Хамгаалах бүс, хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчилд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. | Хамгаалах бүс хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчлийн илрүүлэлт өссөн байна. | 3,6, 9, 12 саруудад | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| **Зорилт 3. "Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй , аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хэрэгжүүлнэ" гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 9 | Орчин үеийн технологид нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, техникийн шардлага хангах, хүрээлэн буй орчинд ээлтэй байх тээврийн хэрэгслийг ашиглахтай холбоотой боловсруулж байгаа хууль тогтоомжийн төсөлд санал өгөх | Санал хүргэгдсэн байна. | Тухай бүр | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | | - |
| 1 | Автотээврийн тухай хууль болон татварын холбогдох хууль тогтоомж, хөдөлгөөн зохицуулах менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах. | Зургаагаас дээш жил ажилласан болон баруун талдаа жолооны хүрдтэй автомашины тоог бууруулах үйл ажиллагааг дэмжин оролцсон байна. | Тухай бүр | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 10 | Мэдээллийн нэгдсэн системийг ашиглан хийх судалгаанд оролцож, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх. | Судалгаанд үндэслэн, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна. | Тухай бүр | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох чиглэлээр хийгдэх судалгаанд дэмжлэг үзүүлэн ажиллах, албан журмын даатгагчдын холбоотой хамтарсан хяналт шалгалт хийх | Жолооч, тээврийн хэрэгслийн даатгалыг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэх судалгаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна. | 3,6,9,12 саруудад | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 12 | Замын хөдлөгөөний аюулгүй байдалд аудит хийх, холбогдох судалгаан, шинжилгээ хийх замаар “хар цэг”-ийг тодорхойлж, ослын шалтгаан нөхцөлийг тогтоож, үр дагаварыг арилгах арга хэмжээ авах. | “Хар цэг” –ийг тодорхойлж, осол гарах нөхцлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан судалгаа, үйл ажиллагаанд хамтран ажилласан байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |
| 13 | Уул уурхайн замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх ажилд дэмжлэг үзүүлэн хамтран оролцох | Тухайн чиглэлээр аудит хийх ажилд дэмжлэг үзүүлэн хамтран оролцсон байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 14 | Орон нутгийн бэлчээр хэсэг, замгүй газарт тээврийн хэрэгслээс үүдэлтэй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах. | Батлагдсан замын хөдөлгөөнөөс гадна бүсэд тээврийн хэрэгсэл ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр урьдчилан сэргийлэх тодорхой ажил зохион байгуулсан байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| **Зорилт 4.“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдмйг гэмт халдлагаа, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна”гэсэн хөтөлбөрийн зорилт:** | | | | | | |
| 1 | Тээврийн хэрэгслийн зогсолт, зогсоолыг хянаж, | Тээврийн хэрэгслийн зогсоолын зөрчлийг таслан | Жилдээ | Цагдаагийн газрын Замын | Дэд зөвлөл | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулах систем нэвтрүүлэхэд хамтран оролцох. | зогсоох нөхцөл бүрдсэн байна. | | цагдаагийн тасаг | | |
| 2 | Улсын чанартай авто замд тээврийн хэрэгслийн дундаж хурдыг хянах хяналтын камер систем нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | Улсын чанартай авто зам дагуу дундаж хурдны хяналтын камерын системийг ашиглаж эхэлсэн байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |
| 3 | Улсын чанартай авто замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий хяналтын пост байгуулах талаар холбогдох байгууллагад санал, танилцуулга хүргүүлэх. | Улсын чанартай авто замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий хяналтын постын тоо нэмэгдсэн байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 4 | Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоох, замын хөдөлгөөний болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд камер суурилуулах үйл ажиллгаанд хамтран оролцож хяналт тавих | Тээврийн хэрэгсэлд камер суурилуулсан эсэхэд хяналт тавина. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | - |
| 5 | Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин зөрчилд шийтгэл оногдуулж ажиллах. | E-Police цахим системд ашиглан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг шийдвэрлэнэ. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | | - |
| 6 | Гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас. | Нийтийн тээврээр зорчихын тулд автобусны буудлаас гэр хүртэл зорчих хэв журам | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | гадна гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагад санал хүргүүлж, хамтран ажиллах | хамгаалаглдсан , гэрэлтүүлэг явган хүний зам, ногоон байгууламж, камер зэрэг явган аүн ая тухтай зорчих бүхий л нөхцөл боломцоо хангагдсан байна. | | тасаг | | |
| 7 | Сургууль цэцэрлэгийг гол, төв, хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг нэвтрүүлэхэд шаардлагатай санал, танилцуулага бэлтгэн хүргүүлэх | Сургуулийн бүс Техникийн шаардлага MNS 6444:2014 стандарт хэрэгжилт хангагдсан байна. | Жилдээ | Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл | 500.0 мян/төг |
| 8 | Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох үйл ажиллагаанд хамтран оролцож, холбогдох санал, танилцуулгыг бэлтгэн хүргүүлэх | Холбогдох санал, танилцуулгыг бэлтгэн хүргэгдэж явган хүний гарцын аюулгүй байдал хангагдсан байна. | Жилдээ | Дэд зөвлөл, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Дэд зөвлөл, | - |

______________oOo____________